

Аудит хийгдсэн байгууллага:
“Дархан хотын соёл амралтын
хүрээлэн” ОНӨААТҮГазар

Огноо: 2025.08.15



ДОТООД АУДИТЫН НЭГЖ: ДАРХАН-УУЛ АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

- ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН -

Аудитын нэр: Байгууллагын дотоод аудит
Жил: 2023, 2024 он

Огноо 2025 он

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ 3000

Илэрсэн асуудлын нэгтгэл

№	Асуудлын утга	Холбогдох ажлын баримтын дугаар	Асуудлын ангилал (нөлөөтэй эсэх)	Нөлөөлөх хууль тогтоомж, дүрэм, журам	Аудитын тайлан д оруулах эсэх
1	Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулаагүй байна	АБ2003	Тийм	Дархан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 21-р тогтоолоор баталсан ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.1, 6.2 дахь заалт	Тийм
2	Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлээгүй байна.	АБ2003	Тийм	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт	Тийм
3	Үйлчилгээний нэр төрлийг олшруулж, үнэ тарифыг тооцоо судалгаанд үндэслэн тогтоогүй.	АБ2003	Тийм	Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт	Тийм
4	Түрээслэгч ААН, иргэнтэй байгуулж байгаа түрээсийн гэрээг шинэчлэн боловсруулаагүй.	АБ2003	Тийм	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2, 3 дахь заалт	Тийм
5	Хүний нөөцийг тогтвортой байдлыг хангаагүй.	АБ2003	Тийм	Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, Дархан сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан	

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ 3000

				ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.12.2,	
6	Ур чадварын нэмэгдлийг эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр олгосон.	АБ2003	Тийм	Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 5.1.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт	Тийм
7	Байгууллагын даргын урамшуулалын талаар	АБ2003	Тийм	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4.1 дэх заалт, Дархан сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан ОНӨААТҮГ-ын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт	Тийм
8	Урамшууллыг ажил дүгнэх журам, шалгуур үзүүлэлтгүйгээр олгосон байна	АБ2003	Тийм	Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн зүйлийн 5.1.2, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт	Тийм
9	Илүү цагийн нэмэгдэл хөлсийг нотлох баримтгүйгээр олгосон.	АБ2003	Тийм	Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, байгууллагын дотоод журмын наймдугаар бүлгийн 8.1.9 дэх заалт	Тийм
10	Ээлжийн амралтын цалинг давхардуулан олгосон	АБ2003	Тийм	Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 5.1.5 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ний өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралтын 3.4.	Тийм

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ 3000

11	Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчидтай ээлжийн амралтын тооцоог хийгээгүй байна.	АБ2003	Тийм	Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 5.1.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 3 дахь заалт	Тийм
12	Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдын ээлжийн амралтын хоногийг дутуу тооцон олгосон.	АБ2003	Тийм	Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.4 дэх заалт	Тийм
13	Орлогын төлөвлөгөөг тооцоо судалгаа гүйцэтгэлд үндэслэн төлөвлөөгүй байна.	АБ2003	Тийм	Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.5, Дархан сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.12.2	Тийм
14	Санхүүгийн тайланд өр төлбөрийг тусгаагүй, тайланг үнэн зөв тайлагнаагүй.			Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 2.5, 2.6	

Хянасан:

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга:

/П.Дагийсүрэн/

Боловсруулсан:

Дотоод аудитор, СХШУБайцаагч

Дотоод аудитор:

/А.Сандагдорж/

АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА:

“ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН” ОНӨААТҮГ

АУДИТЫН ТӨРӨЛ: БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АУДИТ

АУДИТЫН ХУГАЦАА : 2025.07.28-2025.08.12

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ДАРГА: Л.ДАГИЙСҮРЭН

АУДИТЫН БАГИЙН ГИШҮҮД:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ: Ш.ОТГОН

ДОТООД АУДИТОР: А.САНДАГДОРЖ

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Засаглалын хүрээнд	4
1.2. Эрсдэлийн удирдлагын хүрээнд:	5
1.3. Дотоод хяналтын хүрээнд	6
2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ	6
2.1. Аудитын зорилго:	6
2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт	7
2.3. Аудитын арга, аргачлал	7
3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА	8
3.1. Засаглалын талаар	8
3.2. Эрсдэлийн удирдлагын талаар	9
4. АУДИТЫН ҮР ДҮН	10
4.1. Засаглалын хүрээнд:	10
4.2. Дотоод хяналтын хүрээнд:	11
5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ	14

1. ТАНИЛЦУУЛГА

Дархан-Уул аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2025 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө, 23-06-25-02/23 дугаар удирдамжийн дагуу “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГазрын 2023-2024 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэсэн тайланг танилцуулж байна.

1.1. Засаглалын хүрээнд

Дархан соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГазар нь Дархан-Уул аймгийн Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн №15 тогтоолоор байгуулагдан нийт 55 ажилтан албан хаагчтайгаар хөдөлгөөнт тоглоом болон бусад үйлчилгээ, нийтийн эзэмшлийн талбайд хуулийн хүрээнд нийтийг хамарсан соёл олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулах нөхцөлөөр хангах, ногоон байгууламжийн арчилгаа, тордолт, хамгаалалт, нөхөн тайралтыг хариуцах, хөшөө, дурсгал, чимэглэл, явган хүний зам арчлах, соёл амралтын хүрээлэнгийн эзэмшлийн талбайн тэмдэг, тэмдэглэгээ, сандал, хогийн сав, явган хайсны ашиглалт засварыг хариуцах, зэрэг үйлчилгээг үзүүлж байна.

Байгууллагын стратеги, зорилго зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв санхүүжилтын төлөвлөгөөг нөөц бололцоонд тулгуурлан хамтдаа хэлэлцэж төлөвлөж, даргын зөвлөлөөр ажлын тасралтгүй байдал, албан хаагчдын ажиллах нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, хүний нөөцийн хомсдол үүсэх хор хохирол, тулгамдаж буй асуудал, гэнэт үүссэн эрсдэл, ирээдүйд бий болох үр дагаварыг үнэлж төсөвтэйгээ уялдуулан, санхүүгийн хууль дүрэм, журамтай нийцүүлэн эрэмбэлж шийдвэрлэж, засаглах удирдлага нь уг үйл ажиллагааны хэрэгжилт, мониторинг, хяналт, үнэлгээг өгдөг

Тус байгууллага нь тал бүрийн мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагуудаар дамжуулан мэдээлэл, мэдлэг, сургалтыг байнга өгч ажилладаг.

Хөндлөнгийн болон дотоод аудитын дүгнэлтийг үндэслэн тулгамдаж буй эрсдэлт асуудлыг танилцуулж, 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/09 тоот захирлын тушаалаар Дотоод хяналтын зөвлөлийг байгуулж, зөвлөл нь улирал тутам хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил, эрсдэлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх хяналт хийн ажиллаж, байгууллагад учирч байгаа төсөв санхүүтэй

холбоотой асуудлыг сумын Засаг даргад танилцуулан Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулдаг байна.

1.2 Эрсдэлийн удирдлагын хүрээнд:

Эрсдэлийн удирдлагын журам батлуулсан үйл ажиллагаандаа учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж, үнэлж, бууруулах чиглэлд тогтмол арга хэмжээ авч ажилладаг. Дараах үндсэн төрлүүдээр эрсдэлийг ангилан авч үздэг. Үүнд:

- Үйл ажиллагааны эрсдэл (жишээлбэл, тоног төхөөрөмжийн эвдрэл, ажил гүйцэтгэлийн саатал)
- Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэл (осол, гэмтэл, эрүүл мэндийн хүндрэл)
- Цаг агаарын эрсдэл (салхи, бороо, үер, цасны улмаас тохижилтын эвдрэл)
- Хүний нөөцийн эрсдэл (ажилтны орон тоо дутмаг, чадварын асуудал)
- Санхүү, өмч хөрөнгийн эрсдэл (хөрөнгө устах, тоног төхөөрөмжийн элэгдэл)

Эрсдэлийг бууруулах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Үүнд:

- Ажилтан бүрийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр ажилладаг
- Ажлын байрны эрсдэлийг бууруулахаар ХАБЭА зөвлөл хуваарь гарган түрээслэгч нар болон ажлын байрны үзлэг шалгалтыг байнга хийдэг.
- ХАБЭА-ийн сургалт, зааварчилгаа тогтмол зохион байгуулдаг
- Ажилчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулдаг
- Сэтгэлзүйн болон нийгмийн асуудлуудад дэмжлэг туслалцаа, сургалт зохион байгуулдаг.

Эрсдэлийн асуудлыг захиргааны түвшинд хэлэлцэн, зохих нэгжүүдэд хуваарилж ажиллаж, эрсдэлийн үнэлгээний дүнг захирлын дэргэдэх зөвлөл, дотоод хяналтын зөвлөл, ХАБЭА зэрэг холбогдох нэгжүүдэд танилцуулж, байгууллагын батлагдсан журмын дагуу эрсдэлийг өндөр, дунд, бага зэрэг ангилж, “зөвшөөрөх цэг”-ээс хэтэрсэн эрсдэлийг засаглах удирдлага болон холбогдох албан тушаалтанд мэдэгдэн, санхүү, хүний нөөц, хууль, хөдөлмөрийн аюулгүй байдал гэх мэт холбогдох албадын оролцоотойгоор иж бүрэн үнэлгээ хийж, дахин үүсэхээс сэргийлж ажилладаг

Захирлын дэргэдэх зөвлөл болон бусад зөвлөлийн хурлаар тухайн үеийн нөхцөл байдалтай холбоотой шийдвэрийн эрсдэл, байгууллагын стратегид сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг хэлэлцэж, холбогдох ажилтан, албад үүрэг чиглэл өгч, www.ersdel.e-darkhan.mn вэб, аппликейшин мэдээллийн систем нь байгууллагын бүх шатанд нээлттэй, ойлгомжтой, шуурхай байж, эрсдэлийг цаг тухайд нь тодорхойлох, бууруулах, хариу арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1.3 Дотоод хяналтын хүрээнд

“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГазар нь дотоод хяналтын бодлого журамтай боловч, тусдаа нэгж байхгүй, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хязгаарлагдмал хүрээнд дараах хийж байна.

. Журмын хүрээнд:

- Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэл
- Хөрөнгө, бараа материалын хадгалалт, хамгаалалт
- Санхүүгийн зарцуулалт
- Тоног төхөөрөмжийн ашиглалт, бүртгэл

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГазрын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж, дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө зөвлөмж өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Дотоод аудитад “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГазрын 2023-2024 оны засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явц, санхүүгийн үйл ажиллагаа, цалин хөлс олголт, анхан шатны баримт болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, өмч хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, худалдан авах ажиллагаа, өмнөх шалгалт, шилэн дансны хөтлөлт зэргийг хамруулсан болно.

Дотоод аудитад Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газрын 2023-2024 оны санхүүгийн тайлангийн аудитад дурдагдсан асуудлыг хамруулаагүй.

Тус байгууллагын санхүүгийн баримтад Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд дотоод аудит хийж, илэрсэн 2 зөрчилд зөвлөмж, албан шаардлага өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

2.3 Аудитын арга, аргачлал

Дотоод аудитаар байгууллагын удирдлагад дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчим, ёс зүйн дүрмийг танилцуулж, засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны талаар асуулга авсан. Мөн аудитын хамрах хүрээнд багтсан асуудлуудыг байгууллагаас олж авсан мэдээлэл, бичиг баримтад дүн шинжилгээ хийж, түүврийн аргаар сорил хийлээ. Аудитын эдгээр горимын үр дүнд дотоод аудитын баг хангалттай нотолгоо цуглуулж аудитын дүгнэлтээ гаргасан болно. Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримтуудыг эх үүсвэр болгон ашигласан болно. Үүнд:

- Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт
- Улсын салбарын дотоод аудитын гарын авлага
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Цалин хөлс, үйлчилгээний үнэ тарифтай холбоотой Дархан сумын ИТХ-ын шийдвэрүүд
- ОНӨААТҮГ-ын дүрэм, байгууллагын дотоод журам

3.БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

3.1 Засаглалын талаар

Тус байгууллага нь 2022 онд байгуулагдсан бөгөөд орлогын бүрдүүлэлт, хяналт шинжилгээ үнэлгээ, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр амжилт үзүүлэн 2023 оны хөдөлмөрийн аварга байгууллагаар тодорч өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнуулсан байна.

Байгууллагын засаглалын төлөвшлийн үнэлгээг 8 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 3-р түвшин буюу томьёолсон түвшинд байгаа ба Засаглах удирдлага үйл ажиллагааны журамтай, байнгын үйл ажиллагаатай, зөвхөн шаардлагатай үед

дотоод аудит хийдэг, ажилтнууд үнэт зүйлсээ эрхэмлэн, ёс зүйтэй ажиллаж байгаа эсэхийг үнэлэх системтэй, гадаад ба дотоод тайлагналд стандарт тогтоож мөрддөг. Ил тод байдлыг засаглалын хамгийн чухал үзүүлэлт гэж тунхаглан хэрэгжүүлдэг. Олон нийтэд зохих мэдээллийн ил тод гаргаж мэдээлдэг байна.

Дараагийн түвшинд орохын тулд дотоод аудитын нэгжийн үүргийг тодорхойлж, ур чадвартай ажилтан олж авах, засаглах удирдлага стратеги зорилгоо боловсруулахдаа эрсдлийн дуршилын түвшинг тодорхойлон үнэлгээ хийж, бууруулах арга хэмжээг авах, ёс зүй, үнэт зүйлсийн талаар байнгын сургалт, хэлэлцүүлэг хийх шаардлагатай.

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар

Байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийг 7 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 3-р түвшинд буюу томъёолсон түвшинд байгаа ба гүйцэтгэх удирдлага эрсдэлийг тодорхойлж үнэлдэг боловч стратеги, зорилго зорилттой уялдаагүй, том хэмжээний төсөл арга хэмжээнд нэг удаагийн эрсдэлийн үнэлгээ хийдэг. Эрсдэлийн талаар ойлголт зөвхөн удирдлагын түвшинд тогтсон боловч эрсдэлийг удирдаж байгаад дүн шинжилгээ хийдэггүй. Байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх явцдаа залиланг харгалзан үздэггүй.

Эрсдэлийн удирдлагын түвшинг ахиулахын тулд гүйцэтгэх удирдлага эрсдэлийг тодорхойлж үнэлэх, байгууллагын эрсдэлийн бүртгэл хөтлөх, ангилалд /стратегийн, үйл ажиллагааны, хүний нөөцийн, санхүүгийн, хууль тогтоомжийн нийцлийн, мэдээлэл технологийн гэх мэт/ үнэлгээ хийх, эрсдэл бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, эрсдэлийн үнэлгээ хийх явцдаа залиланг харгалзан үзэх хэрэгтэй.

3.3 Дотоод хяналтын системийн талаар

Байгууллагын дотоод хяналтын тогтолцооны төлөвшлийг 7 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 2-р түвшинд буюу давтамжтай түвшинд байгаа ба Засаглах болон гүйцэтгэх удирдлага хоорондоо хараат бус боловч байгууллагын түвшинд хэрэгжүүлэх дотоод хяналтын үйл ажиллагааг тодорхойлоогүй байна. Дотоод хяналтын үйл ажиллагааны талаар дотооддоо мэдээлэл дамжуулах үйл явц байгаа боловч зарим дутагдалтай талууд байдаг. Байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааны сул тал, эрсдэлийн талаар удирдлагад мэдээлэх үйл явц тогтоогүй.

Дараагийн түвшинд шилжихэд хэрэглэгчийн шаардлагыг хангах замаар сэтгэл ханамжийг нь дээшлүүлэх зорилгоор Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-тай нийцүүлэн дотоод хяналтыг хийх, дотоод хяналтын үйл ажиллагааг эрсдэлийн үнэлгээтэй уялдуулан байнга шинэчлэх, дотоод хяналтын үйл ажиллагааг байнга үнэлж, албажуулах шаардлагатай байна.

4.АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн асуудал 1	Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулаагүй байна
Асуудлын ангилал	Нөлөө багатай.
Бодит байдал: Дархан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан байгууллагын дүрэмд төлөөлөн удирдах зөвлөлтэй байна гэж заасан боловч Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулаагүй байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Дархан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 21-р тогтоолоор баталсан ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.1 дэх заалт “Газрын өдөр тутмын үйл ажиллагааг газрын дарга удирдана.Газар нь удирдах зөвлөлтэй байх бөгөөд Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Компаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журамд заасан эрх, үүргийн дагуу төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлнэ”, 6.2 дахь заалт Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна” гэж заасан байна.	
Асуудлын үндсэн шалтгаан : - Байгууллагын удирдлага,нягтлан бодогч нарын хууль эрх зүйн мэдлэг дутмаг, дотоод хяналт сул.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: -Дүрмийн хэрэгжилт хангагдахгүй байх - Удирдлага, дотоод хяналтын багаас тавих хяналт сул, ажлын уялдаа холбоо	

4.1 Засаглалын хүрээнд

муу

Зөвлөмж:

Цаашид хууль журмын хэрэгжилт болон байгууллагын дүрэмд заасан шаардлагад нийцүүлэн ажиллах талаар зөвлөмж өглөө. Дүрэмд заасны дагуу ТУЗ байгуулах, эсвэл холбогдох заалтыг ИТх-аар оруулж өөрчлөх.

Илэрсэн асуудал 2	Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлээгүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө багатай.
Бодит байдал: Тус ОНӨААТҮГ-ын Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 2023 онд 596,8 сая төгрөг 2024 онд 750,5 сая төгрөгийн орлого олсон байна	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "үнэн зөв байх", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт "үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий дараах этгээд албан татвар суутган төлөгч байна", гэж заасан.	
Асуудлын үндсэн шалтгаан : - Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарын хууль эрх зүйн мэдлэг дутмаг, дотоод хяналт сул.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: -Хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хангагдахгүй байх -Удирдлага дотоод хяналтын багаас тавих хяналт сул, ажлын уялдаа холбоо муу	
Албан шаардлага: Цаашид харьяа татварын албанд хүсэлт гарган нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлэх талаар Улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлээ.	

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

Илэрсэн асуудал 3	Үйлчилгээний нэр төрлийг олшруулж, үнэ тарифыг тооцоо судалгаанд үндэслэн тогтоогүй.
Асуудлын ангилал	Нөлөө багатай.

Бодит байдал:

Үйлчилгээний үнэ тарифыг эрх бүхий байгууллага албан тушаалтанаар батлуулсан боловч үйлчилгээний нэр төрлийг олшруулах, үнэ тарифыг тооцоо судалгаанд үндэслэн шинэчлэн тогтоох шаардлагатай байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/: Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт "хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох" заасан.

Асуудлын үндсэн шалтгаан :

- Байгууллагын удирдлага, менежер, нягтлан бодогч нарын хууль эрх зүйн мэдлэг дутмаг, дотоод хяналт сул.
- Үйлчилгээний нэр төрлөөрх үнэ тарифыг Дархан сумын ИТХ-аар батлуулаагүй

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

- Хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хангагдахгүй байх.
- Удирдлага дотоод хяналтын багаас тавих хяналт сул, ажлын уялдаа холбоо муу
- Түрээслэгч төлбөрөө төлөхгүй, санхүүгийн эрсдэл хүлээх

Зөвлөмж:

Эрх бүхий байгууллагад хүсэлт гарган үйлчилгээний нэр төрөл, үнэ тарифыг шинэчлэн боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах талаар зөвлөмж өглөө.

Илэрсэн асуудал 4	Түрээслэгч ААН; иргэнтэй байгуулж байгаа түрээсийн гэрээг шинэчлэн боловсруулаагүй.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал. Тайлант онуудад ААН, иргэнтэй байгуулсан түрээсийн гэрээг гэрээ дүгнэсэн акттай тулган шалгахад түрээсийн гэрээнд ашиглалтын зардлыг	

хэрхэн тооцох талаар тодорхой тусгаагүй, тодорхой шалтгааны улмаас гэрээ цуцлагдсан тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулаагүй байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь заалт “Засгийн газраас тусгайлан журамласнаас бусад үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг төрийн өмчит хуулийн этгээд эдэлнэ”.3 дахь заалт “Түрээсийн гэрээнд Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасан нөхцөлөөс гадна эд хөрөнгө түрээслүүлэх хугацаа, төлбөр, нөхцөл, хугацаанаас өмнө цуцлах үндэслэл, үүсэх үр дагавар, түүнийг арилгах журмыг заавал тусгана” гэж заасан байна.

Асуудлын үндсэн шалтгаан:

Байгууллагын удирдлага, ахлах менежер, нягтлан бодогч нарын хууль эрх зүйн мэдлэг дутмаг, дотоод хяналт сул.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

- Хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хангагдахгүй байх
- Байгууллага төсөв санхүүгийн алдагдалд хүрэх

Зөвлөмж: Түрээсийн гэрээг шинэчлэн боловсруулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах.

4.2 Эрсдэлийн удирдлагын хүрээнд

Илэрсэн асуудал 5	Хүний нөөцийг тогтвортой байдлыг хангаагүй.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал. Тайлант онуудад хүний нөөцийн хөдөлгөөн ихтэй, албан хаагчдыг тогтвортой ажиллуулах бодлогүй, нийгмийн баталгааг хангаж ажиллаагүй байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/:	
Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн “7.1.2.мэргэшсэн тогтвортой байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, Дархан сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.12.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, удирдаж буй газрын хэвийн үйл ажиллагааг хангасны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг бүх талаар	

дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах” гэж заасан байна.

Асуудлын үндсэн шалтгаан:

Байгууллагын удирдлага, ахлах менежер, нягтлан бодогч нарын хууль эрх зүйн мэдлэг дутмаг, дотоод хяналт сул.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

- Байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах
- Ажлын бүтээмж буурах

Зөвлөмж: Хүний нөөцийн тогтвортой ажиллах бодлого барьж ажиллах талаар зөвлөмж өглөө.

4.3.Санхүүгийн үйл ажиллагаа

Илэрсэн асуудал 6	Ур чадварын нэмэгдлийг эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр олгосон.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: Тус байгууллагын дарга нь эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 360.0 мянган төгрөгний ур чадварын нэмэгдэл хөлс авсан байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.3 дахь заалтад “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5 дахь заалтад “хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэнтэй нийцэхгүй байна.	
Асуудлын үндсэн шалтгаан:	
- Байгууллагын дарга, нягтлан бодогчийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллаагүйгээс төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл үүссэн байна.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	
-Хууль тогтоомж, дүрэм,журмын хэрэгжилт хангагдахгүй байх	
- Байгууллага төсөв санхүүгийн алдагдалд хүрэх	
Акт:	
Тушаал шийдвэргүй олгосон ур чадварын нэмэгдэл 360.0 мянган төгрөгийг төлүүлж төсвийн орлогод төвлөрүүлэхээр Улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо	

Илэрсэн асуудал 7	Байгууллагын даргын урамшуулалын талаар
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал : Тайлант онуудын цалингийн баримтыг шалгахад тус байгууллагын дарга нь 2023 онд Дархан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн Б/65 тоот захирамжаар нэмэлт орлогын 5 хувь буюу 26,055.0 мянган төгрөг, 2024 онд Дархан сумын засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Б/52 тоот захирамжаар байгууллагын төсвийн орлогоос давсан нэмэлт орлогын 10 хувь буюу 24,400.0 мянган төгрөг, нийт 50,455.0 мянган төгрөгийн урамшуулал авсан байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4.1 дэх заалт үйлдвэрийн газрын ашгаас тодорхой хугацаанд тодорхой хувиар олгох; Дархан сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан ОНӨААТҮГ-ын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт” газрын даргын улирлын урамшуулал олгох эсэх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ, жилийн эцсийн үр дүнгийн урамшууллыг Төлөөлөн удирдах зөвлөл бизнес төлөвлөгөөтэй уялдуулан 25 хүртэлх хувиар тооцон олгож болно” гэсэнтэй нийцэхгүй байна.	
Асуудлын үндсэн шалтгаан : - Байгууллагын дарга, нягтлан бодогчийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг - Эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллаагүй - Дээд шатны байгууллагаас хяналт тавьж ажиллаагүй	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: - Төсөв, санхүүгийн алдагдал хүлээх - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Дархан сумын ИТХ-ын 2023 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт хангагдахгүй байх	
Албан шаардлага: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байхыг анхааруулж Улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүллээ.	

Илэрсэн асуудал 8	Урамшууллыг ажил дүгнэх журам, шалгуур үзүүлэлтгүйгээр олгосон байна
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал : Тайлант онуудын цалингийн баримтыг шалгахад урамшууллын нэмэгдлийг ажилчдад олгохдоо ажил дүгнэх журам, шалгуур үзүүлэлтгүйгээр 2023 онд 22,710.2 мянган төгрөг, 2024 онд 44,858.6 мянган төгрөг нийт 67,568.7 мянган төгрөгийг олгосон байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн зүйлийн 5.1.2 дахь заалтад “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах”, 5.1.5 дахь заалтад “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт “үнэн зөв байх”; 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”; гэсэнтэй нийцэхгүй байна.	
Асуудлын үндсэн шалтгаан : - Байгууллагын дарга, нягтлан бодогчийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг, - Эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллаагүй - Дээд шатны байгууллагаас хяналт тавьж ажиллаагүй	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: - Цалин хөлсийг илүү болон дутуу тооцсоны улмаас төсөв, санхүүгийн алдагдал хүлээх - Албан хаагчийг хохироох	
Албан шаардлага: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байхыг анхааруулж Улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлээ.	

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

Илэрсэн асуудал 9	Илүү цагийн нэмэгдэл хөлсийг нотлох баримтгүйгээр олгосон.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: Тус байгууллагын 2023, 2024 оны цалингийн баримтыг шалгахад илүү цагийг цагийн бүртгэл дээр тусгасан боловч ямар ажлыг хэдний өдөр хэдэн цагаар хийсэн нь тодорхой бус нотлох баримтгүйгээр 40,995.4 мянган төгрөг олгосон байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах”, 5.1.5 дахь заалтад “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” байгууллагын дотоод журмын наймдугаар бүлгийн 8.1.9 дэх заалт илүү цагийн тайланг бичгээр баталгаажуулж, байгууллагын удирдлагаар батлуулсан байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.	
Асуудлын үндсэн шалтгаан: - Цалин хөлсийг илүү болон дутуу тооцсоны улмаас төсөв, санхүүгийн алдагдал хүлээх - Албан хаагчийг хохироох	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Цалин хөлсийг илүү болон дутуу тооцсоны улмаас төсөв, санхүүгийн алдагдал хүлээх	
Зөвлөмж: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байхыг анхааруулж зөвлөмж өгч ажиллаа.	

Илэрсэн асуудал 10	Ээлжийн амралтын цалинг давхардуулан олгосон
---------------------------	--

Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал :Тайлант онуудын цалингийн баримтыг шалгахад 2023 онд 4 албан хаагчид 373.0 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон зөрчил илэрлээ.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.3 дахь заалтад “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5 дахь заалтад “хариуцлагатай байх” 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ний өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралтын 3.4.-т “ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно” гэсэнтэй нийцэхгүй байна.	
Асуудлын үндсэн шалтгаан : Байгууллагын удирдлага, хүний нөөцийн ажилтан, нягтлан бодогчийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг, дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллаагүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: - Төсөв санхүүгийн алдагдал хүлээж, хэвийн үйл ажиллагаа алдагдах, тайлан тооцоо гүйцэтгэл буруу гарах,үйл ажиллагаанд тавих хяналт сул.	
Акт: Дээрх зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллахыг анхааруулан Зөрчил арилгуулахаар 373.0 мянган төгрөгийн Улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо	
Илэрсэн асуудал 11	Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчидтай ээлжийн амралтын тооцоог хийгээгүй байна.

Асуудлын ангилал	Нөлөө багатай
Бодит байдал:Тайлант онуудын цалингийн баримтыг байгууллагын даргын тушаалтай тулган шалгахад ажлаас чөлөөлөгдөж буй албан хаагчидтай ажилласан хугацааны ээлжийн амралтын тооцоог хийгээгүй зөрчлүүд илэрлээ.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.3 дахь заалтад “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5 дахь заалтад “хариуцлагатай байх, Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 3 дахь заалт “Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно”гэсэнтэй нийцэхгүй байна.	
Асуудлын үндсэн шалтгаан : - Дотоод хяналт сул; -Удирдлага, хүний нөөцийн ажилтан, нягтлан бодогчийн эрх зүйн мэдлэг дутуу	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: -Хууль журмын хэрэгжилт хангагдахгүй байх; - Албан хаагчийг хохироох	
Зөвлөмж: Цаашид алдааг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгч ажиллаа.	

Илэрсэн асуудал 12	Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдын ээлжийн амралтын хоногийг дутуу тооцон олгосон.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй

Бодит байдал :

Тайлант онуудын цалингийн баримтыг шалгахад 2023 онд 5 албан хаагчид 1,127.3 мянган төгрөг, 2024 онд 6 албан хаагчид 1,627.5, нийт 2,754.8 мянган төгрөгийн олговрыг дутуу тооцон олгосон байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2."төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;", 5.1.5 "хариуцлагатай байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.4 дэх заалт "Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна".гэсэнтэй нийцэхгүй байна.

Асуудлын үндсэн шалтгаан :

Байгууллагын дарга, нягтлан бодогчийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллаагүй.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Ажилтан албан хаагчдыг хохироох, санхүүгийн тайлан буруу гарах.

Акт:

Дээрх зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллахыг анхааруулан Зөрчил арилгуулахаар 2,754.8 мянган төгрөгийн Улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо

4.3 Дотоод хяналтын хүрээнд:

Илэрсэн асуудал 13	Орлогын төлөвлөгөөг тооцоо судалгаа гүйцэтгэлд үндэслэн төлөвлөөгүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй

Бодит байдал :

2023 онд түрээсийн орлогыг төлөвлөж бусад орлогыг төлөвлөөгүй, 250,000.0 сая төгрөг, гүйцэтгэлээр 596,811,3 сая төгрөг, 2024 онд 500,000.0 сая төгрөг төлөвлөж 750,564.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2."төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх,"; 5.1.5 "хариуцлагатай байх", Дархан сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.12.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, удирдаж буй газрын хэвийн үйл ажиллагааг хангасны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг бүх талаар дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах" гэж заасан байна

Асуудлын үндсэн шалтгаан :

Байгууллагын дарга, нягтлан бодогчийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллаагүй

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

-Төсөв санхүүгийн эрсдэл үүснэ.

Зөвлөмж:

Цаашид алдааг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгч ажиллаа.

Илэрсэн асуудал 14	Санхүүгийн тайланд өр төлбөрийг тусгаагүй, тайланг үнэн зөв тайлагнаагүй.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй

Бодит байдал :

Тайлант онуудын харилцах, ерөнхий журнал, санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийг шалгахад 2023 оны түрээсийн орлого 4,510.0 авлагаар тусгаагүй 2023 оны 12-р сард олгох дарга Л.Тамирын ур чадварын нэмэгдэл 1,080.0 мянган төгрөгийг 2024 оны 2-р сард олгосон бөгөөд 2023 оны санхүүгийн тайланд өр авлагаар тусгаагүй байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2. "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5.1.5 "хариуцлагатай байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;

2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"

Асуудлын үндсэн шалтгаан :

Байгууллагын дарга, нягтлан бодогчийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллаагүй хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмжийг тайланд тусгаагүй байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Хууль дүрэм журам мөрдөн ажиллаагүйгээс төсөв санхүүгийн алдагдал хүлээх Ажилтан албан хаагчдыг хохироох, санхүүгийн тайлан буруу гарах.

Зөвлөмж:

- Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн холбогдолтой хууль, журам, заавартай сайтар танилцаж судлах
- Харилцагч иргэн, аж ахуй нэгжтэй тооцоо нийлсэн актыг бүрэн үйлдэж байх
- Өр авлагаа баталгаажуулж ажиллах
- Мэргэжлийн байгууллагуудаас заавар зөвлөгөөг тогтмол авч ажиллах

5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дотоод аудитаар танай байгууллагад “САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “давтамжтай” буюу 3-р түвшинд байна гэж үнэлсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 65.0 %-аас дээш “нөлөө ихтэй” гэж үзсэн.

Дүгнэлт:

Засаглал удирдлагын хүрээнд:

Засаглах удирдлага болон гүйцэтгэх удирдлага хоорондоо харилцан уялдаатай ажилладаг. Засаг даргаар байгууллагын жилийн төлөвлөгөөг батлуулан биелэлтийг хагас бүтэн жилээр тайлагнадаг.

ТУЗ байгуулаагүй байна, хүний нөөцийг тогтвортой ажиллуулах бодлого боловсруулах

Эрсдэлийн удирдлагын хүрээнд:

Байгууллагын хэмжээнд эрсдлийн түвшинг тогтоож, бодлого журам баталсан боловч эрсдэлийг шинэчилдэггүй, эрсдэлийн удирдлагын болон үйл явц нь бүрэн тогтоогүй, байгууллагын эрсдлийн үнэлгээ хийх явцдаа залиланг харгалзан үздэггүй байна.

Дотоод хяналтын хүрээнд:

Гүйцэтгэх удирдлагын дотоод хяналтын багийг бүрдүүлж ажиллаж байгаа ч чадвартай ажилтан авах, хөгжүүлэх болон хадгалахад чиглэсэн хүний нөөцийн бодлоготой байх, Дотоод хяналтын үйл ажиллагаанд үнэлгээ хийдэггүй байна,

Зөвлөмж:

Засаглалын хүрээнд:

- Байгууллагын дүрэмд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулах
- Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм журмыг шинэчлэн боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулах;
- Хүний нөөцийг тогтвортой ажиллуулахад анхаарах
- Удирдлагаас гаргаж буй шийдвэр болон байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах;

- Байгууллагын орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөх

Эрсдэлийн удирдлагын хүрээнд:

- байгууллагын эрсдэлийн бүртгэл хөтлөх, ангилалд /стратегийн, үйл ажиллагааны, хүний нөөцийн, санхүүгийн, хууль тогтоомжийн нийцлийн, мэдээлэл технологийн гэх мэт/ үнэлгээ хийх

- Эрсдэлийн бүртгэлийг хийж шаардлагатай бүх тохиолдолд хийж эрэмбэлдэг байх;

- Байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх явцдаа залиланг харгалзан үзэх;

Дотоод хяналтын хүрээнд:

- Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 4 дүгээр зүйлд заасан хяналт шалгалтын үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж тайлагнах;

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ
ДОТООД АУДИТОР



Ш.ОТГОН
А.САНДАГДОРЖ

ТАЙЛАН ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА



Л.ДАГИЙСҮРЭН

ТАНИЛЦСАН:

"ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН"
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА



Л.ТАМИР

НЯГТЛАН БОДОГЧ

Э.ӨЛЗИЙХИШИГ

ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН ОНӨААТҮГ-ЫН
2023-2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын
нэг бүрчилсэн актаар тогтоогдсон зөрчил төлбөрийн жагсаалт

ОНӨААТҮГ
2025 он

	Хариуцах хүний овог нэр	Албан тушаал	Зөрчил төлбөрийн товч утга	Актын дугаар	Нийт дүн	Үүнээс			Зөвлөмж
						Орон нутгийн төсөвт	Тухайн байгууллага хувьчлалын дансанд	Хуулийн байгууллагад шилжүүлэх	
1	Л.Тамир Э.Өлзийхишиг	Дарга Нягтлан бодогч	ТУЗ-ийг байгуулах					Албан шаардлага	Зөвлөмж
2	Л.Тамир Э.Өлзийхишиг	Дарга Нягтлан бодогч	Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч болох					Албан шаардлага	
3	Л.Тамир Э.Өлзийхишиг	Дарга Нягтлан бодогч	Үйлчилгээний үнэ тарифын нэр төрлийг олшруулж, үнэ тарифыг тооцоо судалгаанд үндэслэн тогтоох						Зөвлөмж
4	Л.Тамир Э.Өлзийхишиг. Т.Бат-Оргил	Дарга Нягтлан бодогч Менежер	Түрээслэгч ААН, иргэнтэй байгуулж байгаа Түрээсийн гэрээг ашиглалтын болон шинэчлэн боловсруулах,						Зөвлөмж
5	Л.Тамир Ц.Батхишиг	Дарга Нягтлан бодогч	Хүний нөөцийг тогтвортой ажиллуулах						Зөвлөмж
6	Л.Тамир Ц.Батхишиг	Дарга Нягтлан бодогч	Ур чадварын нэмэгдэлийг эрх бүхий албан тушаалтаны тушаал шийдвэргүйгээр олгосон		360,000	360,000			
7	Л.Тамир Ц.Батхишиг. Б.Эрдэнэтогтох	Дарга Нягтлан бодогч	Үндэслэлгүйгээр олгосон урамшуулал		53,587,000			53,587,000	Албан шаардлага
8	Л.Тамир Ц.Батхишиг. Б.Эрдэнэтогтох	Дарга Нягтлан бодогч	Үнэлэх шалгуур үзүүлэлтгүйгээр урамшуулал олгосон		38,236,736			38,236,736	Албан шаардлага
9	Л.Тамир Ц.Батхишиг. Б.Эрдэнэтогтох	Дарга Нягтлан бодогч	Илүү цагийн нэмэгдэл хөлсийг нотлох баримтгүйгээр олгосон		40,995,414				40,995,414
10	Л.Тамир Ц.Батхишиг	Дарга Нягтлан бодогч	Эзлжийн амралт цалинг давхардуулан олгосон		373,014	373,014.0			



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН АКТ

2025 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 23-06-25/54

Дархан

┌ НЭМЭГДЭЛ ХӨЛС ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ ┐

Дархан-Уул аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2025 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө, 23-06-25-02/23 дугаар удирдамжийн дагуу “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГазрын 2023-2024 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

Тус байгууллагын дарга нь эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 360.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл хөлс авсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.3 дахь заалтад “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5 дахь заалтад “хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар ба талгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.3.1, 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндэслэлгүйгээр олгосон нэмэгдэл хөлс 360.0 мянган төгрөгийг “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГазрын дарга Л.Тамир, нягтлан бодогч асан Ц.Батхишиг нараар төлүүлсугай.

2. Дээрх актын төлбөр 360.0 мянган төгрөгийг 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор СХДАГ-ын актын төлбөр орлого Төрийн сан банкны 100190000986 тоот дансанд төвлөрүүлэхийг “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГазрын дарга Л.Тамир, нягтлан бодогч Э.Өлзийхишиг нарт хариуцуулав.

4577010118

Эс зөвшөөрвөл Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалтад “Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээдээс түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хууль болон зорилгодоо нийцэж байгаа эсэх талаар хянуулахаар гомдол гаргах эрхтэй” болохыг дурьдсугай.

АКТ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Л.ДАГИЙСҮРЭН


САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ



Ш.ОТГОН

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН
ХҮРЭЭЛЭН ОНӨААТҮГ-ЫН ДАРГА



Л.ТАМИР

НЯГТЛАН БОДОГЧ

Э.ӨЛЗИЙХИШИГ

НЯГТЛАН БОДОГЧ АСАН

Ц.БАТХИШИГ



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН АКТ

2025 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 23-06-25/55

Дархан

ЭЭЛЖИЙН АМРАЛТЫН ОЛГОВОР
ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ

Дархан-Уул аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2025 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө, 23-06-25-02/23 дугаар удирдамжийн дагуу “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ-аар 2023-2024 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

Шалгалтын хугацаанд албан хаагчдын цалингийн баримтыг шалгахад 2023 онд 4 албан хаагчид 373.0 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.3 дахь заалтад “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5 дахь заалтад “хариуцлагатай байх” 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ний өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралтын 3.4.-т “ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно” гэсэнтэй нийцэхгүй байна.

Иймд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.3.1, 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Илүү олгосон 373.0 мянган төгрөгийг ажилтнууд, дарга, нягтлан бодогч нараар төлүүлж төсвийн орлогод төвлөрүүлэх.

417040119

2. Дээрх актын төлбөр 373.0 мянган төгрөгийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор СХДАГ-ын актын төлбөр орлого Төрийн сан банкны 100190000986 тоот дансанд төвлөрүүлэхийг “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГазрын дарга Л.Тамир, нягтлан бодогч Э.Өлзийхишиг нарт хариуцуулав.

Эс зөвшөөрвөл Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалтад “Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээдээс түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хууль болон зорилгодоо нийцэж байгаа эсэх талаар хянуулахаар гомдол гаргах эрхтэй” болохыг дурьдсугай.

АКТ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Л.ДАГИЙСҮРЭН

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ш.ОТГОН

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН
ХҮРЭЭЛЭН ОНӨААТҮГ-ЫН ДАРГА

Л.ТАМИР

НЯГТЛАН БОДОГЧ

Э.ӨЛЗИЙХИШИГ

НЯГТЛАН БОДОГЧ АСАН

Ц.БАТХИШИГ



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН АКТ

2025 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 23-06-25/56

Дархан

ДУТУУ ОЛГОСОН ЭЭЛЖИЙН АМРАЛТЫН
ОЛГОВОР ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ

Дархан-Уул аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө, 23-06-25-02/23 дугаар удирдамжийн дагуу “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГазрын 2023-2024 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

Тайлант онуудын цалингийн баримтыг шалгахад 2023 онд 5 албан хаагчид 1,127.3 мянган төгрөг, 2024 онд 6 албан хаагчид 1,627.5 мянган төгрөг, нийт 2,754.8 мянган төгрөгийн олговрыг дутуу тооцон олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2. “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;”, 5.1.5 “хариуцлагатай байх” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.4 дэх заалт “Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна” гэсэнтэй нийцэхгүй байна.

Иймд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.3.1, 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Дутуу олгосон 2,754.8 мянган төгрөгийг хавсралтад дурьдсан албан хаагчдад нөхөн олгох

2. Дээрхи төлбөр 2,754.8 мянган төгрөгийг тухайн ажилтанд олгосоныг 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр хариу мэдэгдэхийг “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГазрын дарга Л.Тамир, нягтлан бодогч Э.Өлзийхишиг нарт хариуцуулав.

4505040191

Эс зөвшөөрвөл Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалтад “Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээдээс түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хууль болон зорилгодоо нийцэж байгаа эсэх талаар хянуулахаар гомдол гаргах эрхтэй” болохыг дурьдсугай.

АКТ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Л.ДАГИЙСҮРЭН

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ш.ОТГОН

ДОТООД АУДИТОР

А.САНДАГДОРЖ

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН
ХҮРЭЭЛЭН ОНӨААТҮГ-ЫН ДАРГА

Л.ТАМИР

НЯГТЛАН БОДОГЧ

Э.ӨЛЗИЙХИШИГ



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 23-06-25/91

Дархан

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Дархан-Уул аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2025 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө, 23-06-25-02/23 дугаар удирдамжийн дагуу “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГазрын 2023-2024 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

Тус ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 2023 онд 596.8 сая төгрөг, 2024 онд 750.5 сая төгрөгийн орлого олсон бөгөөд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт “үнэн зөв байх”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт “Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий дараах этгээд албан татвар суутган төлөгч байна” гэсэнтэй нийцэхгүй байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.3.1, 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтуудыг үндэслэн илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар **ШААРДАХ** нь:

1.Харьяа татварын албанд хүсэлт гарган нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлэх

2. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалтын дагуу албан шаардлагаар өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж холбогдох арга хэмжээ авч ажиллах, биелэлтийг 2025 оны 10 дугаар 25-ны өдрийн дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

Эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалтад “Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээдээс түүний эрх, хууль

48-5050213

ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хууль болон зорилгодоо нийцэж байгаа эсэх талаар хянуулахаар гомдол гаргах эрхтэй” болохыг дурдсугай.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Л.ДАГИЙСҮРЭН

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ш.ОТГОН

ДОТОООД АУДИТОР

А.САНДАГДОРЖ

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:

ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА



Л.ТАМИР

ЕРӨНХИЙ НЯТЛАН БОДОГЧ

Э.ӨЛЗИЙХИШИГ



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 23-06-25/92

Дархан

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Дархан-Уул аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө, 23-06-25-02/23 дугаар удирдамжийн дагуу “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ-ын газрын 2023-2024 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

Тайлант онуудын цалингийн баримтыг шалгахад тус байгууллагын дарга нь 2023 онд Дархан сумын засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн Б/65 тоот захирамжаар нэмэлт орлогын 5 хувь буюу 26,055.0 мянган төгрөг, 2024 онд Дархан сумын засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 23 -ны өдрийн Б/52 тоот захирамжаар байгууллагын төсвийн орлогоос давсан нэмэлт орлогын 10 хувь буюу 24,400.0 мянган төгрөгийн урамшуулал авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 20 дугаар зүйлийн 4.1 дэх заалт үйлдвэрийн газрын ашгаас тодорхой хугацаанд тодорхой хувиар олгох; Дархан сумын ИТХ-ын 2023 олны 12 дугаар сарын 19-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан ОНӨААТҮГ-ын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт” газрын даргын улирлын урамшуулал олгох эсэх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ, жилийн эцсийн үр дүнгийн урамшууллыг Төлөөлөн удирдах зөвлөл бизнес төлөвлөгөөтэй уялдуулан 25 хүртэлх хувиар тооцон олгож болно” гэсэнтэй нийцэхгүй байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.3.1, 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтуудыг үндэслэн илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар **ШААРДАХ нь:**

1. Эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллах

413050215

2. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалтын дагуу албан шаардлагаар өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж холбогдох арга хэмжээ авч ажиллах, биелэлтийг 2025 оны 10 дугаар 25-ны өдрийн дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

Эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалтад “Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээдээс түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хууль болон зорилгодоо нийцэж байгаа эсэх талаар хянуулахаар гомдол гаргах эрхтэй” болохыг дурдсугай.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Л.ДАГИЙСҮРЭН

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ш.ОТГОН

ДОТОООД АУДИТОР

А.САНДАГДОРЖ

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:

ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА

Л.ТАМИР

ЕРӨНХИЙ НЯТЛАН БОДОГЧ

Э.ӨЛЗИЙХИШИГ



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 23-06-25/03

Дархан

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Дархан-Уул аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө, 23-06-25-02/23 дугаар удирдамжийн дагуу "Дархан хотын соёл амралтын хүрээлэн" ОНӨААТҮГ газрын 2023-2024 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

Тайлант онуудын цалингийн баримтыг шалгахад урамшууллын нэмэгдлийг ажилчдад олгохдоо ажил дүгнэх журам, шалгуур үзүүлэлтгүйгээр 2023 онд 22,710.2 мянган төгрөг, 2024 онд 44,858.6 мянган төгрөг нийт 67,568.7 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн зүйлийн 5.1.2 дахь заалтад "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах", 5.1.5 дахь заалтад "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэнтэй нийцэхгүй байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.3.1, 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтуудыг үндэслэн илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар **ШААРДАХ нь**:

1. Эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллах

2. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалтын дагуу албан шаардлагаар өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж холбогдох арга хэмжээ авч ажиллах, биелэлтийг 2025 оны 10 дугаар 25-ны өдрийн дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

4873000217

Эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалтад “Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээдээс түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хууль болон зорилгодоо нийцэж байгаа эсэх талаар хянуулахаар гомдол гаргах эрхтэй” болохыг дурдсугай.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Л.ДАГИЙСҮРЭН

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН

УЛСЫН БАЙЦААГЧ

Ш.ОТГОН

ДОТОООД АУДИТОР

А.САНДАГДОРЖ

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:

ДАРХАН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН

ОНӨААТҮГ-ЫН ДАРГА

Л.ТАМИР

ЕРӨНХИЙ НЯТЛАН БОДОГЧ

Э.ӨЛЗИЙХИШИГ